



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

Г “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат  
компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,  
зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн  
гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал А.Баясгалантай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал А.Баясгалантай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул Гүйцэтгэх захирал А.Баясгаланд хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4.Гүйцэтгэх захирал А.Баясгаланд хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхбилэгтэйд зөвшөөрсүгэй.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 04 дугээр сарын 18-ны өдрийн  
130. дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭСАНТ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЗАХИРАЛД  
2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

| д/д | Хуулийн<br>этгээдийн<br>нэр | Захирлын нэр | Цэвэр ашиг<br>(төг) | Цэвэр ашгийн<br>дүнгээс хасаж<br>тооцох валютын<br>ханшийн<br>өөрчлөлтөөс<br>олсон ашиг<br>алдагдал (төг) | Урамшуулал<br>тооцох цэвэр<br>ашиг<br>(төг) | Олгох<br>урамшууллын<br>хэмжээ (төг)  |
|-----|-----------------------------|--------------|---------------------|---|---|---|
| 1   | "Эрдэнэсант<br>АЗЗА" ТӨХК   | А.Баясгалан  | 117,410,623.48      | 0.00  | 117,410,623.48                              | 7,348,212.47<br>(долоон сая<br>гурван зуун<br>дөчин найман<br>мянга хоёр<br>зуун арван<br>хоёр төгрөг<br>дөчин долоон<br>мөнгө) |

.....000.....